

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ, СУМДЫН
2020 ОНЫ 7 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2020.08.05

Сүхбаатар сум

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчдийн үйл ажиллагааны талаар

Сэлэнгэ аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид энэ сард 1 удаа хуралдаж 6 асуудал хэлэлцэн 6 тогтоол баталлаа. Үүнд:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 15 дугаар тогтоолын хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар аймгийн Эрүүл мэндийн газрын даргын сонсгол мэдээллийг хэлэлцээд “Хүн амын дундах сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдварын өвчлөл, тархалтыг бууруулах талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын хэрэгжилтийн явц, үр дүнг “Хангалттай” гэж дүгнэлээ. Мөн тухайн өвчлөл, тархалтыг бууруулах ажилд сайтар анхаарч, халдварт өвчинтэй тэмцэх чиглэлээр хөтөлбөр, төлөвлөгөөг гарган шаардлагатай төсөв хөрөнгийг жил бүрийн төсөвт тусан хэрэгжүүлэхийг сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга нарт даалгалаа.

2.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 143 дугаар тогтоолоор батлагдсан “Суралцагч байгууллага-Төрийн албаны манлайлал” аймгийн хөтөлбөрийн биелэлтийн явц, үр дүнгийн талаарх аймгийн Засаг даргын мэдээллийг хэлэлцээд тус хөтөлбөрийн хэрэгжилтийн явц үр дүнг “Хангалттай” гэж дүгнэлээ. Цаашид хөтөлбөрийн хэрэгжилт дуусах хүртэлх хугацаанд хөтөлбөрт тусгагдсан ажил, арга хэмжээнүүдийг бүрэн хэрэгжүүлж, шаардлагатай зардлыг жил бүр аймгийн төсөвт тусган ажиллахыг аймгийн Засаг даргад даалгалаа.

3.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 142 дугаар тогтоолоор батлагдсан “Сэлэнгэ аймгийн гадаад харилцааг эдийн засагжуулах хөтөлбөр”-ийн биелэлтийн явц, үр дүнгийн талаарх аймгийн Засаг даргын мэдээллийг хэлэлцээд хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг “Хангалттай” гэж дүгнэв. Цаашид хөтөлбөрийн хэрэгжилт дуусах хүртэлх хугацаанд хөтөлбөрт тусгагдсан ажил, арга хэмжээнүүдийг бүрэн хэрэгжүүлж, шаардлагатай зардлыг жил бүр аймгийн төсөвт тусган ажиллахыг аймгийн Засаг даргад даалгалаа.

4.Тогтоолд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцээд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 22 дугаар тогтоолоор баталсан “Үндсэн хөрөнгө актлаж, данснаас хасах зөвшөөрөл олгох тухай” тогтоолын хавсралтаар баталсан актлах үндсэн хөрөнгийн жагсаалтаас Алтанбулаг сумын “Бохир усны цэвэрлэх станцын барилга” гэснийг хасаж тогтоов.

5.Сум орон нутаг, иргэдээс ирүүлсэн хүсэлтийг үндэслэн Сайхан суманд үйл ажиллагаа явуулж буй Христийн шашны “Хайрын жим” сүмийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хугацааг 3 жилийн хугацаагаар сунгалаа.

6.Эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан зарим хүмүүсийг төрийн одон медалиар шагнуулахаар МУ-ын Ерөнхийлөгчид уламжиллаа. Үүнд: Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 7, Алтан гадас одонгоор 6, Цэргийн хүндэт медалиар 2, Хөдөлмөрийн хүндэт медалиар 12 иргэнийг шагнуулахаар уламжиллаа.

Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах аймгийн салбар комисс буюу аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нэмэлт санхүүжилтийн дансанд 2020 оны 7-р сард 1 иргэний 40.0 сая (дөчин сая) төгрөгийн нөхөх олговрын хуваарилалт орсон. Улсын төсвийн байгууллагуудад харьяа дээд шатны байгууллагаас хуваарилж буй хөрөнгийн эрхийн баталгааг (ЗЭБ№03) тухай бүр үйлдэн нөхөх олговрын шилжүүлгийг хийлээ. Үүнд: Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийн үр хүүхэд болох нэхэмжлэгч С.Даваадоржид 40.0 сая төгрөгийн нөхөх олговрыг олголоо.

2020 оны 7-р сарын байдлаар Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийн дагуу нөхөх олговор олгох тухай шүүхийн шийдвэр нь гарч хүлээгдэж буй 14 иргэний 600,0 сая төгрөгийн нөхөх олговор хүлээгдэж байна.

Мөн оны эхний 7 сарын байдлаар аймгийн Цагаатгалын салбар комиссоос нийт 33 иргэнд 1 тэрбум 643.0 сая төгрөгийн нөхөх олговрыг олгуулан ажиллаад байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн даргын 2020 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн тушаалаар Төрийн албаны зөвлөлийн гишүүн Б.Зүмбэрэлхам тэргүүтэй ажлын хэсэг манай аймагт ажиллалаа. Тус ажлын хэсэг өнөөдөр орон нутгийн удирдлагууд, төрийн тусгай албан хаагчидтай уулзалт хийж, сумдын ЗДТГ-ын дарга нартай цахимаар, агентлагийн удирдлагууд, хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдтэй сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж зөвлөн туслах чиглэлээр ажиллалаа. Сургалт, хэлэлцүүлэгт 25 байгууллагын 60 гаруй төрийн албан хаагч хамрагдлаа. Энэ үеэр ажлын хэсгийн зүгээс “Төрийн албаны тухай” хуулийн хэрэгжилт, шинэтгэлийн үед хийгдэж буй үйл ажиллагааны талаар мэдээлэл өгсөн юм. Тодруулбал: “Төрийн албаны шинэтгэл ба шинэ хандлага”, “Төрийн захиргааны байгууллагад бодлогын инновацийг туршин нэвтрүүлэх зөвлөмж” зэрэг сэдвийн хүрээнд оролцогчид шинэ мэдээлэлтэй боллоо.

Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй төрийн үйлчилгээг нэг цэгээс хүргэх ажлын хүрээнд Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газартай хамтран аймгийн төвийн үйлчилгээний нэгдсэн төв болон Баруунбүрэн, Зүүнбүрэн, Түшиг, Хушаат, Ерөө, Сант, Орхон, Баруунбүрэн, Баянгол сумдад операторийн горимоор үйлчлэх нөхцлийг бүрдүүлэх бэлтгэлийг хангаж, 7-р сарын 01-03-ны өдрүүдэд аймгийн Засаг даргын Тамгын газрын холбогдох мэргэжилтэн, дээрх сумдын ЗДТГ-ын дарга, төрийн захиргаа, хууль, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг чадавхижуулах сургалтад хамруулж, техник, тоног төхөөрөмжийг хүлээлгэн өглөө.

Ардын хувьсгалын 99 жилийн ой, Сэлэнгэ аймаг байгуулагдсаны 89 жилийн ой, үндэсний их баяр наадмыг энэ сарын 11-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүллээ. Үндэсний их баяр наадмын хурдан морины уралдаанд оролцсон унаач хүүхдийн эрх ашгийг хамгаалах, эрүүл мэнд, аюулгүй байдалд хяналт тавьж 17 суманд чиглэл өгч ажиллалаа.

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.2, 27.1.3 дахь заалт, “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 2.1, 2.3-т заасныг үндэслэн Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөлийн захиалгаар 18 албан тушаалын 28-н сул орон тооны зарын дагуу Төрийн албаны зөвлөлтэй хамтран удирдах ажилтны болон гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалтыг цахим шалгалтыг зохион байгууллаа. Сонгон шалгаруулалтад тусгай шаардлагыг хангасан 10 иргэн бүртгүүлж оролцсон.

Онцгой байдлын ажил үйлчилгээний талаар

Монгол улсын Засгийн газрын 2019 оны 331 дүгээр тогтоолоор Хүдэр суманд Эрэн хайх аврах салбар шинээр байгуулахаар шийдвэрлэсэн бөгөөд эхний ээлжинд томилогдсон алба хаагчдыг үүрэг гүйцэтгэх ажлын байранд хүргэн өгч байрны засвар үйлчилгээний ажлыг эхлүүлээд байна.

Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх талаар гарсан тогтоол, шийдвэр, Улсын онцгой комиссоос өгсөн чиглэлийн дагуу аймгийн Онцгой комисс 5 удаа хуралдаж үүссэн нөхцөл байдлын үед хэрэгжүүлэх арга хэмжээгээ төлөвлөн ажиллаж байна. Аймгийн Онцгой комиссын шийдвэрээр 04 дүгээр сарын 23-25-ны өдрүүдэд аймгаас орох гарах хөдөлгөөнийг түр хугацаанд хязгаарлах арга хэмжээ авч ажилласан.

Аймгийн хэмжээнд энэ сарын эхээр тусгаарлалтад 26 иргэн байснаас өнөөдрийн байдлаар 10 иргэн, гэрийн ажиглалтад 52 иргэн байна.

ОХУ-аас 405 ачаа тээврийн том оврын автомашин нэвтэрсэн. Уг машинуудыг ариутгал халдваргүйжүүлэлтэд хамруулан цагдаагийн байгууллагын хяналт дор Улаанбаатар, Дархан-Уул, Орхон аймгуудын гүний хяналтад шилжүүлж ажиллалаа.

Хуурайшилтын зэрэг нэмэгдэж аюултай түвшинд хүрсэнтэй холбогдуулан ой хээрт үйл ажиллагаа явуулахыг хориглох, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх хяналтын цэг ажилуулах тухай аймгийн Засаг даргын захирамж гарч эрсдэл өндөр сумддад мэргэжлийн байгууллагын албан хаагчдын бүрэлдэхүүнтэй ажлын хэсгүүд 2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлэн үүрэг гүйцэтгэж эхэлсэн.

Тайлант хугацаанд аймгийн Онцгой байдлын газарт аюулт үзэгдэл, ослын 12 удаагийн дуудлага ирсэн. Үүнд:

-Гэр орон сууцны гал түймрийн 7

-Усны ослын 1

-Ой хээрийн түймрийн 4 дуудлага тус тус ирсэн байна.

Дуудлагын дагуу газрын албан хаагчид үүрэг гүйцэтгэж, ахуйн болон ой хээрийн түймрийг бүрэн унтраасан. Усны ослын дагуу эрлийн ажиллагааг зохион байгуулж байна.

Гол нуурын мөсөнд цөмрөх, эд хөрөнгө амь насаа алдах эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөмж ярилцлага, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, шар усны үер, хүчтэй цасан болон шороон шуурганаас урьдчилан сэргийлэх заавар зөвлөмжүүдийг sea.nema.gov.mn, Сэлэнгэ аймгийн Онцгой байдлын газрын page хуудас, аймгийн ЗДТГ-ын page хуудас, Сэлэнгэ зар зэрэг олон нийтийн цахим сүлжээгээр иргэдэд түгээн ажилласан.

Стандартчилал, хэмжил зүйн үйл ажиллагааны талаар

Стандартчилал, тохирлын үнэлгээ, баталгаажуулалтын чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

Үйлчилгээний баталгаажуулалт:

Баянгол, Сүхбаатар сумын 3 аж ахуйн нэгжийн 2 хүнсний дэлгүүр, 1 кафены газрын үйл ажиллагаанд тохирлын үнэлгээ хийж тохирлын гэрчилгээний хугацааг сунгаж, тохирлын гэрчилгээ олгов.

Бүтээгдэхүүн баталгаажуулалт

Ерөө сумын Бугант тосгоны худалдаа үйлчилгээ эрхлэгч 19 иргэнд “MNS 5021-1:2019 Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ, ерөнхий шаардлага” стандартаар сургалт хийж, холбогдох хууль, тогтоомжийн талаарх мэдээллийг өгч, гарын авлага материалаар хангав. “Болд төмөр Ерөө гол” ХХК-ий Баянголын уурхайн хоолны газрын үйлчилгээнд нь баталгаажуулалт хийсэн.

Стандартын салбар сан:

Стандартын мэдээллийн салбар сангаас 15 аж ахуйн нэгж байгууллага, иргэний захиалгын дагуу 4 нэрийн 16 стандартын борлуулалт хийж, арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Хэмжил зүйн лабораторийн ажил, үйлчилгээ

Болд төмөр Ерөө гол” ХХК-ий 2 шатахуун түгээх станцын 5 шатахуун түгээгүүр болон “Сүхбаатар депо”-ийн 2 шингэний тоолуурыг шалган баталгаажуулсан. Худалдаа үйлчилгээ эрхлэгч ААН-ийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй 53ш жинг шалгаж ээлжит бус баталгаажуулалтад хамруулсан. Мөн цахилгааны хэмжлийн төрлөөр айл өрх, аж ахуй нэгжийн үйл ажиллагаанд ашиглагдаж буй 41ш цахилгааны тоолуур, 2 ширхэг даралтын аппаратыг шалган баталгаажуулсан.

Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

**1.Төсвийн гүйцэтгэлийн талаар: /2020 оны 06 дугаар сарын гүйцэтгэлээр/
Аймгийн хэмжээнд 2020 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан нэгтгэлтэй холбогдуулан**

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1. Орон нутгийн төсвийн нийт орлого		27,616,010.9	25,646,500.6	92.9
1.1	Орон нутгийн төсвийн орлого	6,237,259.2	5,857,908.8	93.9
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	4,853,470.3	4,252,625.3	87.6
	Сумдын төсвийн орлого	1,383,788.9	1,605,283.5	116.0
1.2	Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	1,952,741.0	1,952,741.0	100.0
1.3	Улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлэг	15,544,482.9	15,544,482.9	100.0
1.4	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг	1,232,063.9	389,126.7	31.6
1.5	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/	1,600,526.5	1,600,526.5	100.0
1.6	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/	301,714.7	301,714.7	100.0
1.7	Сум хөгжүүлэх сан /орлого/	747,222.7	234,703.5	
2. Орон нутгийн төсвийн нийт зарлага		27,616,010.9	19,833,645.0	71.8
2.1	Орон нутгийн төсвийн нийт зарлага	27,616,010.9	19,833,645.0	71.8
	Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага	4,804,975.1	3,495,463.8	72.7
	Сумдын орон нутгийн хөгжлийн сан	241,098.9	25,567.6	-
	Сумдын сум хөгжүүлэх сан	-	-	-
	Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын зарлага	4,621,819.1	2,320,201.0	50.2
	Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт	1,005,088.8	189,857.6	18.9
	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	1,120,571.6	291,020.3	26.0
	Халамжийн сан	69,757.5	14,400.0	20.6
	Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага	2,224,049.8	1,658,826.9	74.6
	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө	202,351.4	166,096.2	82.1
	Сумдын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	17,636,925.5	13,702,562.3	77.7
	Аймгийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага	311,192.3	289,850.4	93.1
3. Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг		21,758,727.8	20,039,828.2	92.1
3.1	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	4,982,181.0	4,106,218.6	82.4
3.2	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	35,335.5	35,335.5	100.0
	Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд	35,335.5	35,335.5	100.0
	Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд	-	-	
	Хөрөнгө оруулалтын зардалд	-	-	

3.3	Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	1,196,728.4	353,791.2	29.6
	Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд	1,158,123.4	315,186.2	27.2
	Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд	38,605.0	38,605.0	
3.4	Сумдад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	15,235,988.2	15,235,988.2	100.0
3.5	Аймагт олгосон тусгай зориулалтын шилжүүлэг	308,494.7	308,494.7	100.0
3.6	Тусгай зориулалтын шилжүүлэг /салбараар/	15,544,482.9	15,544,482.9	100.0
	- Ерөнхий боловсролын сургууль	8,311,751.7	8,311,751.7	100.0
	- Хүүхдийн цэцэрлэг	4,869,305.8	4,869,305.8	100.0
	- Эрүүл мэндийн байгууллага	2,016,147.2	2,016,147.2	100.0
	- Газрын кадастрын байгууллага	179,242.1	179,242.1	100.0
	- Хүүхдийн байгууллага	168,036.1	168,036.1	100.0
4. Тусгай сангуудын зарлага		747,222.7	234,703.5	31.4
4.1	Сумдын сум хөгжүүлэх сан	747,222.7	234,703.5	31.4

2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл		2019 06- сар	2020 06- сар	2020- 06 2019-06 Х/төгрөгөөр/
1.ХҮНСНИЙ БАРАА				
1	ТАЛХ, ГУРИЛ, БУДАА			
	Гурил /савласан, кг/	1 100	1 200	109.1
	Талх /орон нутгийн, ш/	1 200	1 300	108.3
	Нарийн боов /кг/	2 500	2 500	100.0
	Будаа /кг/	2 400	2 600	108.3
	Элсэн чихэр /кг/	2 200	2 000	90.9
2	МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН			
	Хонины мах /кг/	8 500	8 000	106.3
	Үхрийн мах /кг/	9 000	9 500	105.6
	Адууны мах /кг/	7500	7 500	100.0
	Ямааны мах /кг/	7 000	7 800	111.4
	Дотор мах, цувдай /цусгүй/	4000	5 000	125.0
	Хиам /чанасан, кг/	10 000	11 000	110.0
3	СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ			
	Сүү /задгай, л/	1 000	1 000	100.0
	Сүү / савласан, л/	2 700	3200	118.5

	Тараг /задгай, л/	1 300	1 200	92.3
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	15 000	16 000	106.7
	Айраг /л/	3 500	4 000	114.3
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	4 500	4 500	100.0
	Өндөг /ш/	350	350	100.0
4	БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС			
	Ургамлын тос /л/	3 800	4 500	118.4
	Өөхөн тос /кг/	2 000	2 500	125.0
	Шар тос /кг/	13 000	15 000	115.4
	Масло /задгай, кг/	4 500	4 500	100.0
5	ХҮНСНИЙ НОГОО			
	Төмс /кг/	1 000	1 100	110.0
	Лууван /кг/	3000	1 200	40.0
	Манжин /кг/	1200	2 000	166.7
	Байцаа /кг/	1500	1200	80.0
	Сонгино /кг/	1500	2 000	133.3
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	3 500	4 500	128.6
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	2 800	3 000	107.1
7	ШАТАХУУН			
	Бензин А - 80	1 770	1 360	76.8
	Бензин А - 92	1 890	1 420	75.1
	Дизелийн түлш	2 370	1900	80.2

Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

Аймгийн Засаг даргын 2020 оны 07-р сарын 16-ны өдрийн А/203 дугаар захирамжаар хүний эрхийг хангах, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилго бүхий “Хүний эрхийн төлөө хамтдаа” аян, А/204 дүгээр захирамжаар авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилго бүхий “Авлига, ашиг сонирхлын зөрчилгүй байгууллага, хамт олон” аян, А/207 дугаар захирамжаар хил хамгаалах албыг бэхжүүлэх, хил хамгаалалтад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд “Нэг мянгат малчин-нэг агт” аяныг өрнүүлэх ажлуудыг тус тус эхлүүлэн ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд 2020 оны эхний 6 сард 224 холбогдогчтой 654,8 сая төгрөгийн хохиролтой, 318 гэмт хэрэг бүртгэгдэж урьд оны мөн үеэс 83-аар буюу 20.7 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

2020 оны эхний 6 сард 9041 зөрчил илрүүлсэн нь 5076 зөрчлөөр буюу 36.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Улсын бүртгэлийн хэлтсээс 07 дугаар сард газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ 210 олгож үйлчиллээ.

Иргэний бүртгэлийн чиглэлээр

- ✓ Төрсний бүртгэл – 140 /эрэгтэй-60, эмэгтэй-80/
- ✓ Гэрлэлтийн бүртгэл – 23
- ✓ Гэрлэлт цуцалсны бүртгэл – 8
- ✓ Үрчлэлт - 3
- ✓ Эцэг тогтоолт – 8
- ✓ Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл – 2
- ✓ Нас баралт – 33
- ✓ Нийт олгосон иргэний үнэмлэх – 284
- ✓ Шинээр олгосон иргэний үнэмлэх – 110
- ✓ Дахин олгосон иргэний үнэмлэх – 64
- ✓ Иргэний үнэмлэхний хугацаа дуусч солиулсан – 116
- ✓ Гадаад паспорт олголт – 7тус тус бүртгэгдэж, 47 иргэн шилжин ирсэн байна.

Зам барилга ашиглалтын конторын хөмрөгийн 1981-1994 оны 53 хн-д хэсэгчилсэн тооллогыг хийж иж бүрэн нягтлан шалгалт, ЭШТБ-ын ажлыг эхлүүлээд байна.

Баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд Сэлэнгэ аймаг дахь арилжааны банк, Аж ахуйн нэгжүүдийн хөмрөг, Цагааннуур сумын ЗДТГ-ын хөмрөгийн нийт 52 1979-2010 оны 52 хн-ний 5637 хуудас баримтын агуулгыг уншиж заалт 4091, хүний нэр 15816, газарзүйн нэр 1636, байгууллагын нэр 530-г шивж эх баримттай холбох ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн Цагааннуур сумын ЗДТГ-ын хөмрөгийн 43 хн-ний 4757 хуудас баримтыг сканердаж мастер хувь үүсгэж DVD дээр хуулж нөөц хувь үүсгэсэн.

Иргэд, албан байгууллагын хүсэлтийн дагуу архивын хуулбар цахимаар 157, цаасан суурьтай баримтнаас 36, мастер хувиас 31, нийт 224-г, малын А данс 1, цалингийн баримт 2, тодорхойлолт, магадлагаа -23-г тус тус гаргаж үйлчилсэн.

Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

1.Боловсрол, соёл урлаг, спортын талаар

Боловсролын тухай 31 дүгээр зүйлд боловсролын асуудлаар сум, дүүргийн Засаг даргын хэрэгжүүлэх бүрэн эрхийг тогтоосон бөгөөд хуулийн 31.1.12-т "Аймаг, нийслэлийн боловсролын газрын сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчийг томилж, тэдгээрийг үр дүнгийн гэрээний хэрэгжилт болон аймаг, нийслэлийн боловсролын газрын саналыг үндэслэн чөлөөлөх" гэж заасныг 2020 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлэн ажиллаж байна.

Элсэлтийн ерөнхий шалгалтын батламж хуудсыг тараах, МИДСК-ийн болон гишүүн бус сургуулиудад 7 бүлэг, 18 дэд бүлгээр оюутан элсүүлэх үйл ажиллагааг 07 дугаар сарын 06-16-ны өдрүүдэд зохион байгуулсан.

Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй "Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар хүртээмжийг сайжруулах" төслийн хүрээнд "Сургуульд суурилсан менежмент"-ийн сургалтыг аймаг бүрээс 1 сургуулийг сонгох ажлын хүрээнд сургуулийн захирал болон удирдах ажилтнууд асуулгад оролцохыг цахимаар мэдэгдэж ажилласан.

"Бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулах тухай" аймгийн Засаг даргын захирамжийн дагуу 07 дугаар сарын 08-ны өдөр бүх нийтийн цэвэрлэгээ, шарилж устгах ажилд мэргэжилтэн, ажилтнууд оролцож, байгууллагын эргэн тойрны 50м газрыг цэвэрлэсэн.

2020-2021 оны шинэ хичээлийн жилийн сурах бичгийг хэвлэлийн компаниас хуваарийн дагуу авч ерөнхий боловсролын сургуулиудад хүргүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

2.Эрүүл мэндийн талаар:

Улсын Онцгой комиссын шийдвэрийн дагуу 2020 оны 4-р сарын 23-ны өдрөөс эхлүүлэн Алтанбулаг боомтоор орж ирж байгаа ачаа тээврийн том автомашины жолооч нарыг хамар залгиур, ам залгиурын шинжилгээнд хамруулж, тухай бүр Дархан-уул аймгийн Нэгдсэн эмнэлгийн вируслогийн лабораторид шинжлүүлсэн. Тус өдрөөс эхлүүлэн 2578 ачаа тээврийн жолооч нарыг шинжилгээнд хамруулсан бөгөөд Беларусь-5, ОХУ-5, Казасктан-1, Монгол-1 нийт 12 коронавирустэй жолоочийг илрүүлэн ХӨСҮТ-д хүргэсэн.

3.Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний талаар:

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж хөнгөлөлтийн үйлчилгээг зорилтот бүлэгт түргэн шуурхай, хүнд сурталгүй чанартай хүргэх, халамжийн шинэ үйлчилгээг нэвтрүүлэхэд төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоотойгоор 17 сум 6 тосгонд хүргэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд халамжийн санд улсын төсвөөс 34343 иргэнд 10047710,4 мянган төгрөгийг зарцууллаа.

Үүнд:

Орон нутгийн төсвийн орлогоос:

2020 оны 7 сарын байдлаар Онцгой тохиолдлын тэтгэмжид 21 иргэнд 25200,0 мянган төгрөг

Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 122 иргэн хамрагдаж 41972,4 мянган төгрөгийг тус тус олгосон.

Улсын төсвийн орлогоос:

Халамжийн санд улсын төсвөөс 34200 иргэнд 9980538,0 мянган төгрөгийг олгоод байна.

Үүнд:

1. Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2432 иргэнд 3655228,0 мянган төгрөг
2. Нийгмийн халамжийн тэтгэмжид 1729 иргэнд 963184,5 мянган төгрөг
3. Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмжид 1594 иргэнд 621678,8 мянган төгрөг
4. Жирэмсэн эхийн тэтгэмжид 1151 эхэд 222534,1 мянган төгрөг
5. 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж 5295 эхэд 1589777,2 мянган төгрөг
6. Өрх толгойлсон эх/эцэгийн тэтгэмж 224 иргэнд 119676,9 мянган төгрөг
7. Ахмадын настанд олгох хөнгөлөлт, тусламжинд 2035 ахмадын 214720,9 мянган төгрөг
8. Алдар цолтон ахмад настанд 59 ахмадын 53825,5 мянган төгрөг
9. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх хөнгөлөлт, тусламжинд 208 иргэний 61248,0 мянган төгрөг
10. Алдарт эхийн одон 8692 эхэд 1130300,0 мянган төгрөг
11. Насны хишиг үйлчилгээг 5020 ахмадад 762400,0 мянган төгрөг
12. Ихэр хүүхдийн тэтгэмж 21 хүүхдэд 42000,0 мянган төгрөг
13. Хүнсний эрхийн бичгийн 5740 иргэнд 543964,1 мянган төгрөгийг тус тус зарцууллаа.

Хөдөлмөр халамжийн үйлчилгээний ерөнхий газраас тендерт шалгарч Сэргээн засах үйлчилгээ явуулах эрх авсан ЭБУС ХХК, Бум хараа ХХК, Энэрэлт үйлс ХХК, Хараа Алтан-Од ХХК-уудтай хамтран ажиллах гэрээ байгуулж, Сүхбаатар, Мандал суманд сэргээн засах үйлчилгээг үзүүлэн нийт 271 ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэн хүүхдийг хамруулсан байна. Үүнд Сүхбаатар суманд Хөгжлийн бэрхшээлтэй иргэн 32, ахмад настан 90, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд 11 хамрагдсан. Мандал суманд Хөгжлийн бэрхшээлтэй иргэн 21, ахмад настан 112, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд 5 хамрагдсан байна.

2020 оны 6-р сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй 669 байсан бол 96 иргэн шинээр бүртгүүлж, ажил олгогчоос ирүүлсэн 28 ажлын байранд 23 хүнийг ажилд

зуучилж, идэвхгүйн улмаас 6 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 736 болсон байна.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд өрхийн малжуулах арга хэмжээнд Баруунбүрэн, Сант, Зүүнбүрэн, Хушаат, Хүдэр, Ерөө сум Бугант, Хэрх тосгоны 30 өрхийг хамруулж хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 141000.0 мянган төгрөгийг зарцуулж үр дүнд 60 ажлын байр шинээр бий болсон.

4. Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар

Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвөөс 9 дуудлага мэдээллийг хүлээн авч хамтарсан багт шилжүүлж хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэн ажиллалаа. Дуудлагыг агуулгаар нь ангилахад:

- Үл хайхрах хүчирхийлэл – 3
- Сэтгэл санаа-5
- Бие махбод-2

Хүчирхийлэл үйлдэгдсэн орчноор нь ангилбал:
-Гэр бүлийн орчинд – 6

Эрсдэлийн түвшингөөр ангилбал:

Өндөр эрсдэлтэй – 1

Дунд эрсдэлтэй – 7

Бага эрсдэлтэй -2 нийт 10 тохиолдлыг хяналтандаа авч ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд “Дунгийн эгшиг” яруу найргийн наадмыг цахимаар 2 үе шаттайгаар 3 насны ангилалаар зохион байгуулсан. Наадамд 12 сум 4 тосгоны 49 яруу найрагч хүүхдүүд авьяас билиг, оюун ухаанаа сорьж оролцож, ангилал тус бүр шилдэг 5 хүүхэд нийт 5 сум, 4 тосгоны 15 хүүхэд 2-р шатанд үлдэж

Бага нас 1-4-р анги

1-р байр: Б.Орхон Сүхбаатар сум

2-р байр: Г.Наму-Үжин Дулаанхаан тосгон

3-р байр: А.Амарзаяа Бугант тосгон

Дунд нас 5-9-р анги

1-р байр: Ө.Шинэцэцэг Түнхэл тосгон

2-р байр: Б.Хатанзаяа Хүдэр сум

3-р байр: М.Намуун Сүхбаатар сум

Ахлах нас 10-12-р анги

1-р байр: Ц.Цэлмэг Хушаат сум

2-р байр: Т.Намуун Мандал сум

3-р байр: Б.Хонгорзул Түнхэл тосгон ерөнхий боловсролын сургуулийн

сурагчид эхний 3 байранд шалгарсан.

Аймгийн баяр наадмаар хурдан морины уралдаач хүүхдийн эрүүл мэнд аюулгүй байдлыг хангаж 17 суманд 6 тосгонд зөвлөн туслах баг ажилласан. Аймгийн баяр наадмаар хурдан морины уралдаанд есөн насны нийт 1220 хурдан морьд, давхардсан тоогоор 565 унаач хүүхэд уралдсан. Уралдааны үед даага, их насаны уралдаанд 2 хүүхэд мориноос унаж хөнгөн гэмтэл авч эрүүл мэндийн эмнэлэгийн тусламж дэмжлэг үзүүлж, хяналтандаа авч ажилласан.

5. Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ажил үйлчилгээний талаар:

Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөгөөр эхний 4 сард 10,6 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 4 дүгээр сарын 25-ны байдлаар өссөн дүнгээр 9,7 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөний хэрэгжилт 91,1 хувийн биелэлттэй байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 17250 тэтгэвэр авагчдад 19,614,454 мянган төгрөгийг тэтгэвэрт, тэтгэмжийн даатгалын сангаас 1728 хүнд 905,211 мянган төгрөгийг хөдөлмөрийн чадвараа түр алдсан, жирэмсэн амаржсан, оршуулгын

тэтгэмжид, Үйлдвэрийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас үйлдвэрлэлийн ослын тэтгэвэр, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, нөхөн төлбөр, сувиллын зардалд 207 хүнд 287,244 мянган төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 107 хүнд 316,079 мянган төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмжид тус тус олгосон.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс энэ сард нийт 4 удаа хуралдаж, 511 хүн орсоноос 405 хүн актыг сунгаж, 66 хүн шинээр тогтоож, 40 хүний актыг цуцалсан байна.

Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн архивын лавлагааг байдлаар 477 лавлагааг иргэд, аж ахуй нэгжид цахим болон цаасан хэлбэрээр гарган түргэн шуурхай үйлчилсэн.

Тав.Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хүрээнд

1.Үйлдвэр, хөдөө аж, ахуй, мал эмнэлгийн үйлчилгээний талаар:

Аймгийн хэмжээнд хаврын тариалалтад үр тарианы 251 аж ахуй нэгж, 105 иргэн, төмс, хүнсний ногооны 95 аж ахуйн нэгж, 2251 иргэн 181,0 мянган га талбайд тариалалт хийсэн.

Тариалалтын төлөвлөгөөг бүрэн белүүлж, тариалалтын эцсийн байдлаар 161.7 мян.га талбайд үр тариа тариалсанаас улаан буудай 154.9 мян.га буюу 109 хувьтай, 958 га-д арвай, 4106 га-д овьёос, 1750 га гурвалжин будаа, тэжээлийн ургамал 6342 га буюу 50 хувьтай, тосны ургамал 25.3 мян.га буюу 141 хувьтай, төмс 2822 га буюу 112 хувьтай, хүнсний ногоо 2829 га буюу 108 хувьтай байна.

Аймгийн хэмжээнд 2020 онд 123,0 мянган га-д талбайд уринш боловсруулж, бэлтгэхээр 340 иргэн, аж ахуйн нэгж мэдээлэл ирүүлснээс уриншийн захиалгыг ХХААХЯ-д хүргүүлснээр уриншийн нэгдүгээр боловсруулалтыг хийсэн байна.

Мөн газар тариалангийн тогтвортой хөгжлийг хангах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын тогтоолын хэрэгжилт, цар тахлын онцгой байдлын нөхцөл үүссэн энэ цаг үед, үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний хангамжийг нэмэгдүүлэх, нөөц бүрдүүлэх, дотоодод үйлдвэрлэх, 2020 оны тариалалтыг нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газраас олгох 150,0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлэнд хамруулахаар үр тарианы 277 аж ахуй нэгж, 160 иргэн, төмс, хүнсний ногооны 95 аж ахуйн нэгж, 2251 иргэний судалгааг авч Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яаманд уламжлан арилжааны банкуудаар зээл олгогдож эхлээд байна.

Мөн Сэлэнгэ аймгийн өрх бүр өөрсдийн хэрэгцээний төмс, хүнсний ногоогоо тарьж ургуулан өрхийн хэрэгцээгээ хангахыг уриалан төмс, хүнсний ногооны тариалах талбайн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор Шинэ хөдөө төслийн хүрээнд Төмс, хүнсний ногооны үр олгох, Өсвөрийн хээлтүүлэгч олгох, Ногоон тэжээлийн үр олгох, Хүлэмж олгох гэсэн 4 багц тендерийг зарлаж, 4 аж ахуйн нэгжтэй шууд гэрээ байгуулан ажиллаж байна. .

Хүнсний ногооны үйлдвэрлэлийг нэмэгдүүлснээр 7 сарын 02-оос эхлэн Мандал, Баянгол, Орхон, Шаамар зэрэг сумдын ногоочид эрт ургацын ногоог зах зээлд гарган өнөөдрийн байдлаар 6,6 тн төмс, 138,1, тн хүнсний ногоог худалдан борлуулсан байна.

Сэлэнгэ аймгийн хэмжээнд хаврын тариалалтын хугацаанд хур бороо сайтай байсан тул соёлолто сайн байсан. 153,8 мян.га талбайд соёлолтын үзлэг зохион байгуулан үзлэгийн дүнгээр 48569 га буюу 31,6 хувь нь онц, 92208,8 га буюу 59,9 хувь нь сайн, 9884 га буюу 6,4 хувь нь дунд, 3157 га буюу 2,1 хувь нь муу үнэлгээтэй байна. Соёлолтын дүнг ХХААХҮЯаманд хүргүүлсэн.

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээний гүйцэтгэлд сумын МЭТ-ийн улсын байцаагч нар мал эмнэлэг үйлчилгээний нэгжүүдэд тогтмол хяналт тавьж, мэдээллийг нэгдсэн системд тухай бүр оруулж, Баянгол, Ерөө, Зүүнбүрэн, Шаамар,

Цагааннуур, Мандал, Хүдэр, зэрэг сумдын 257 малчин, мал бүхий өрхөөр гүйцэтгэлийн хяналт хийсэн байна.

Мал эмнэлгийн нэгдсэн цахим системийг ажиллуулах талаар МЭЕГ-аас ирүүлсэн үүрэг чиглэлийн дагуу мал эмнэлгийн тасаг, мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн малын эмч нарт мал эмнэлгийн үйлчилгээний талаарх мэдээ мэдээлэл, бүртгэлмэдээллийгоруулахталаар заавар, зөвлөгөө өгч мал эмнэлгийн нэгдсэн системээр мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд адуу 88, үхэр 500, хонь 2439, ямаа 497, гахай 10 бүгд 3534 толгой мал амьтан шилжилт хөдөлгөөн хийж, 46515кг мах, махан бүтээгдэхүүн, 13466 кг/л сүү, сүүн бүтээгдэхүүн, арьс шир 67792ш/кг бүгд 248473кг/ш бүтээгдэхүүнд мал эмнэлгийн гэрчилгээ олгож баталгаажууллаа Мал эмнэлгийн гэрчилгээг цахим хэлбэрээр олгож аймгийн хэмжээнд 1949 иргэнд цахим гэрчилгээ олгож адуу адуу 774, үхэр 2142, хонь 9980, ямаа 5604, тэмээ 8, гахай 48 нийт 18556 толгой мал амьтан шилжилт хөдөлгөөн хийсэн байна.

Мал эмнэлгийн нэгдсэн цахим системийг ажиллуулах талаар мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдийн малын эмч нарт заавар, зөвлөгөө өгч хэвийн ажиллагааг хангаж байна

. Монгол улсын Засгийн газрын 2018 оны 225 тоот тогтоолын 1-р хавсралт, аймгийн Засаг даргын А/110 тоот захирамжаар халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд давхардсан тоогоор 600000 толгой мал, амьтан (боом 530.0, томуу 30.0, галзуу 28.0, ГСМ 12.0 толгой) хамрагдахаас технологит хугацаанд 580000 толгой мал, амьтан (боом 530000, томуу 15000, галзуу 28000, ГСМ 12000 толгой) буюу 97.5 %-ийг хамруулж, цахим системд оруулсан байна.

Аймгийн Засаг даргын А/110 тоот захирамжаар МУЗГ-ын 225 тоот тогтоолын 2-р хавсралтаар санхүүжүүлэх тарилганд давхардсан тоогоор 200200 толгой мал, амьтан хамрагдахаас технологит хугацаанд 200200 толгой мал, амьтан (Дотрын халдварт хордлого 18000, дуут 90000, цусан халдварт 80000, тугалын иж балнад 6200, гахайн цусан халдварт 6000 иж балнад толгой) буюу 100 %-тай байна. МУЗГ-ын 225 тоот тогтоолын 3-р хавсралт дахь иргэд, ААНБ-аас төлбөр авах тарилганд давхардсан тоогоор 390000 толгой мал хамрагдахаас 39.0 мянган (шөвөг яр 365000, сахуу 25000 толгой) толгой мал, амьтан хамрагдаж, гүйцэтгэл 100%-тай байна. Аймгийн хэмжээнд шүлхий өвчнийг илрүүлэх эмнэлзүй болон ийлдэс судлалын тандалт шинжилгээг 3 сумын 6 багийн 30 малчин өрхийн 3 төрлийн малаас 450 сорьц дээжийг санамсаргүй түүврийн аргаар цуглуулж, цус авснаас 24 цагийн дотор ийлдсийг ялгаж, хүйтэн хэлхээний горимд ийлдсийн санд хадгалж байна.

Шимэгч тэх, зооноз Фасциолёз, цистицеркоз, бэтэг өвчний илрүүлэх тандалт шинжилгээг манай аймагт хамтран судлах тухай албан хүсэлтийг МЭЭШХүрээлэнгийн гельменттэх өвчин, эгэл биет судлалын секторт тавьж байсан. Одоогоор тухайн секторт Мандал сумын Мал нядлагааны газар болон гол ус, булаг шанд зэргээс сорьц дээж хүргүүлсэн. Мөн бэтэг өвчний чиглэлээр 2 эмчийг мэргэшүүлж бэлтгэж, сургалтанд хамруулсан.

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын баталсан халдварт, гоц халдварт, шимэгчтэх өвчинтэй тэмцэх заавар, журмыг сумдын МЭТ, МЭҮН-ийн байцаагч, малын эмч нарт 2 удаа цахим сургалт зохион байгуулсан.

Аймгийн хэмжээнд халдваргүй өвчний мэдээг сумд дахь МЭТасгаар гаргуулан авч, нэгтгэн халдваргүй өвчнөөр нийт 355 толгой мал, амьтан өвчилсөн байна. Үүнээс үхсэн 40 эдгэрсэн 315 толгой мал, амьтан мэдээллэгдснийг мэдээллийн сан бүрдүүлэн ажилласан.

2. Байгаль орчны талаар:

Сумын болон сум дундын Ойн ангитай хамтран Цагааннуур, Баруунбүрэн, Хүдэр, Зүүнбүрэн, Ерөө, Ерөө сумын Бугант тосгонд тус газрын даргын баталсан удирдамжийн дагуу ажлын хэсэг мод бэлтгэлийн ажилд хяналт шалгалтыг гүйцэтгэж байна. Аймгийн Засаг даргын 2020 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн А/168 тоот захирамжийн дагуу Татварын хэлтэстэй хамтран Хүдэр, Ерөө, Мандал, Баянгол сумдын нутгаар усны орлого төвлөрүүлэх ажлыг зохион байгуулж аймгийн төрийн санд 143 750 000 төгрөгийг төвлөрүүлэн ажилласан.

Ерөө сумын Бугант тосгоны Сонгинын алтан шороон орд “Баяжмал алт” ХХК ТЭЗҮ, БОНБНҮнэлгээний тайлан, 2020 оны ашиглалтын үйл ажиллагааны төлөвлөгөө, 2020 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө, усны гэрээ зэрэг бичиг баримтын бүрдэлтийг бүртгэн хянан баталгааны хуудас олгосон

Байгаль орчны мэргэжлийн байгууллага Аргаль агнуур судлалын төв ТББ-иар Орхон голын загасны судалгаа гүйцэтгүүлэхээр ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. Орхон туул, Баруунбүрэн, Орхон, Сайхан, Сант, Шаамар, Сүхбаатар зэрэг сумдыг дамжин урсдаг Орхон голд хээрийн судалгааны ажлыг дээрх сумдын байгаль хамгаалагч нартай хамтран хийж гүйцэтгэж байна.

4. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын талаар:

Барилга, Хот байгуулалтын Сайдын 2020 оны 38 дугаар тушаалаар батлагдсан “Хот байгуулалтын мэдээллийн сангийн журам”-ийн хэрэгжилтийг хангуулах, ГЗБГЗЗГ-ийн даргын 2019 оны 05 дугаар сарын 15- ний өдрийн А/96 тоот тушаалаар “Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сан”-ийн өгөгдөл бүрдүүлэх инженерийн дэд бүтцийн цахилгаан хангамж, дулаан хангамж, ус хангамж, ариутгах татуурга, хот тохижилт, ногоон байгууламжийн авто зогсоол, усан оргилуур , явган болон дугуйн зам, хөшөө дурсгал, гудамж талбайн гэрэлтүүлгийн мэдээлэл бүртгэх маягт батлагдсан ба эдгээр маягтаар хөгжүүлсэн байрлалд суурилсан цахим вэб програм хангамжийг хэрэглээнд нэвтрүүлэх ажлын программд 325 барилга орсон байснаас нийт 354 барилга мэдээллийн санд бүртгэгдсэн байна.

Зураг төсөл хянасан байдал:

1. Ерөө сум “Болдтөмөр Ерөө Гол” ХХК –ний уурхайн кемп, оффисын барилга.
2. Мандал сум Орон сууцны гадна талбайн тохижилтын ажил.
3. Мандал сум ЗДТГазрын барилгын дотор засвар.
4. Мандал сум Спорт ордны барилгын заалны шал, дээврийн солих засварлах.
5. Мандал сум Янзагахан цэцэрлэгийн барилгын засвар.
6. Мандал сум Мөнгөн хараа чуулгын барилгын фасад засвах.
7. Цагааннуур сумын ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн А байр, дотуур байр, гал тогооны барилгын засварын ажил.
8. Баруунбүрэн сумын цэцэрлэгийн барилгын засвар.
9. Сайхан сумын 24 –р цэцэрлэгийн барилгын засвар.
10. Сүхбаатар сум “Миний Булаг” ХХК –ний 1 давхар кафены зориулалттай өргөтгөлийн барилга.
11. “WASH” төслийн хүрээнд Сэлэнгэ аймаг сүхбаатар сумын 6 –р сургуулийн ариун цэвэр эрүүл ахуйн барилгын зураг.
12. Сэлэнгэ аймгийн Орхон сумын спорт заалны барилга /Скиз/

Архитектур төлөвлөлтийн даалгавар гаргаж өгсөн байдал:

1. Ерөө сум Болдтөмөр Ерөө Гол ХХК -ний уурхайн кемпийн оффисын барилга.
2. Орхон сум Спорт заалны барилга.

Барилга угсралтын ажилд ажил эхлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл олгосон байдал:
Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг нийт барилгын их засвар болон угсралтын 11 ажилд олгосон.

1. Соёлын төвийн засварын ажил /Хушаат сум/
2. 4-р сургуулийн өргөтгөлийн ажил /Сүхбаатар сум/
3. 200 хүүхдийн цэцэрлэг /Ерөө сум/
4. Соёл спорт цогцолборын барилгын засварын ажил /Мандал сум/
5. Хөтөл жимстэй хорооллын гэрэлтүүлгийн ажил /Сайхан сум/
6. Гэр хорооллын гудамжны гэрэлтүүлэг хийх ажил /Баянгол сум/
7. Хатуу хучилттай зам тавих /Ерөө сум/
8. Эрүүл мэндийн төвийн барилгын их засварын ажил /Орхонтуул сум/
9. Прокурорын барилгын дээвэр, фасад засварын ажил /Сүхбаатар сум/
10. Орон сууцнуудын кодтой хаалга суурилуулах ажил /Сүхбаатар сум/
11. Сургуулийн барилгын засварын ажил /Хүдэр сум/

Барилга байгууламжид захиалагчийн хяналтыг хэрэгжүүлэн ажилласан байдал:

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналт хэрэгжүүлэн ажиллах ажлын хүрээнд дараах барилга байгууламжид явцын хяналт шалгалтыг хийж холбогдох үүрэг даалгавар, заавар зөвлөмжийг өгч ажилласан.

Шаамар сумын Дулаанхаан суманд баригдсан төрийн албан хаагчдын 8 айлын орон сууцны барилга угсралтын ажилд 2020.06.26-ны өдөр улсын комисс ажиллаж үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээлцүүлсэн

Шаамар суманд баригдсан “Нийтийн ахуй үйлчилгээ, халуун усны барилга” угсралтын ажилд 2020.06.26-ны өдөр улсын комисс ажиллаж үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээлцүүлсэн.

Алтанбулаг суманд баригдсан “Спорт заал”-ны барилга угсралтын ажилд 2020.06.25-ны өдөр улсын комисс ажиллаж үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээлцүүлсэн.

Сайхан суманд “Амар реконстракшн” ХХК-ны гүйцэтгэсэн гэр хорооллын гэрэлтүүлэг шинээр хийх ажилд 2020.06.30-ны өдөр улсын комисс ажиллаж байнгын ашиглалтад хүлээлцүүлэв.

Хүдэр сумын “Соёлын төвийн барилгын засвар”-ын ажлыг “Хүнх сэрвэх” ХХК гүйцэтгэж 2020.07.06-ны өдөр улсын комиссоор байнгын ашиглалтад хүлээлцүүлсэн.

Хүдэр суманд гэр хорооллын гэрэлтүүлэг нэмэгдүүлэх, шинээр суурьлуулах ажлыг “Амар реконстракшн” ХХК гүйцэтгэж 2020.07.06 –ны өдөр улсын комиссоор байнгын ашиглалтад хүлээлцүүлсэн.

Хүдэр сумын инженерийн шугам сүлжээний засварын ажлыг “Сэлэнгэ ундрам” ХХК гүйцэтгэж 2020.07.06-ны өдөр үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээлцүүлсэн.

Төрийн албан хаагчдын 120 айлын орон сууцны барилгын гадна цахилгаан хангамжийн ажилд 2020.07.08-ны өдөр улсын комисс ажиллаж үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээлцүүлсэн.

Сүхбаатар сумын 4-р багийн нутаг дэвсгэрт хийгдсэн тоглоомын талбай барих ажилд 2020.07.09-ны өдөр улсын комисс ажиллаж үүрэг даалгаврын биелэлтээр байнгын ашиглалтад хүлээлцүүлсэн.

ГХБХБГазрын даргын 2020.06.28-ны өдөр баталсан Баруунбүрэн, Сант, Орхон, Орхонтуул, Сайхан сумдад ажиллах удирдамжийн дагуу дээрх сумдын нэгдсэн инженерийн шугам сүлжээний судалгаа, барилгын материал үйлдвэрлэл болон түгээмэл тархацтай материалын судалгаа, ундны усны эх үүсвэрийн судалгааг нэгтгэж мэдээллийн сан үүсгэлээ.

Мөн төр төсвийн барилга байгууламжуудаар үзлэг шалгалтыг хийж эвдрэл гэмтлийн талаарх мэдээллийг барилгын хувийн хэрэгт бичиж тэмдэглэн үлдээсэн.

Сэлэнгэ аймгийн Алтанбулаг суманд баригдаж буй хоногт 100м³ бохир ус цэвэрлэх хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажил дууссантай холбогдуулан Барилгын Хөгжлийн Төвийн нийтийн аж ахуйн хэлтэс, зураг төсөв зохиогч байгууллагуудын төлөөллүүдтэй хамтран улсын комиссын өмнөх урьдчилсан үзлэг шалгалтыг хийж ажил гарсан зөрчил дутагдлуудыг засах хугацаатай үүрэг даалгаврын өгч биелэлтийг хангаж ажиллахыг үүрэг даалгавар болгов.

Зургаа.Сум орон нутгийн ажил үйлчилгээний талаар:

Сум, орон нутгийн түвшинд төрийн ажил үйлчилгээ хэвийн явагдаж байна. Амралт зугаалгын улирал эхэлсэнтэй холбогдуулан аймгийн Онцгой байдлын газар, Цагдаагийн газруудтай хамтран сум орон нутагт ирж буй иргэд олон нийтэд сэрэмжлүүлэг тараан зөвлөгөө өгч ажилласан.

Аж ахуйн нэгж байгууллага, худалдаа үйлчилгээ, нийтийн хоол, зочид буудал зэрэг байгууллагуудын ариутгал цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлт хийх, гар ариутгах нөхцөл бүрдүүлэх, үйлчлэгч болон үйлчлүүлэгчид хувийн ариун цэврийг сахих, амны хаалт зүүж хэвших, амны хаалтгүй иргэдэд үйлчлэхгүй байх, шаардлага тавих, эцэг эхчүүд бага насны хүүхдийг гадуур дагуулж явах, үйлчлүүлэх, үйлчлэхийг хориглох, согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа үйлчилгээний газруудын үйл ажиллагаа, худалдан борлуулах цагийн хязгаарлалт, нийгмийн хэв журмыг хангах, иргэд олон нийтийн аюулгүй байдлыг хяналт тавин ажиллаж байна.

Улсын онцгой комиссын шийдвэрийн хүрээнд Үндэсний баяр наадам зохион байгуулах комиссыг байгуулан, хорио цээрийн дэглэмийг мөрдүүлэн, бүх сумд, тосгод 2020 оны 07 дугаар сарын 11 өдөр тэмдэглэн өнгөрүүлээ. Баяр наадмын үеэр хурдан морины уралдаанч хүүхдийн аюулгүй байдал, бүртгэлийг хариуцан морины комисс ажилласан. Уралдаанч хүүхдийн хамгаалалтын хувцас хэрэгсэл, даатгалыг бүрэн шалгаж уралдуулсан. Баяр наадмын үеэр ил задгай, зөөврийн хоол, хүнсний бүтээгдэхүүний худалдаа үйлчилгээ явуулахыг хориглон, элдэв хордлого, халдварт өвчнөөс сэргийлэн ажиллаа. Наадмын талбайд наадамлаж буй иргэдэд амны маск зүүх, гараа ариутгах, бага насны хүүхдийг дагуулан явахгүй байх талаар анхааруулга, шаардлага тавьж ажиллалаа.